



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/392

Алтай хот

Газар эзэмших эрх хүчингүй болгох
тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газрын төлбөрөө 5 жил дараалан төлөөгүй "Каритас Монгол" ТББ-ын газар эзэмших эрхийг хүчингүй болгосугай.

2.Газар эзэмших эрх нь цуцлагдсан "Каритас Монгол" ТББ-д 10 хоногийн дотор албан ёсоор мэдэгдлийг хүргүүлж холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Ц.Эрдэнэбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР